

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2022/48/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Ахлах аудитор: У.Ербол Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn</p>
---------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа	15
4.2 Төлбөрийн акт	15
4.3 Албан шаардлага	15
4.4 Зөвлөмж.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

**БУЛГАН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 3 ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Д.АМГАЛАН ТАНАА**

2022.08.21 № 00
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн одог улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	37,428,884.00	34,215,977.00
33	АВЛАГА	3,462,384.00	45,577.00
33100	Ажилагчидтай холбогдсон авлага	1,462,384.00	45,577.00
335	Бусад авлага	2,000,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	2,000,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	33,966,500.00	34,170,400.00
354	Хангамжийн материал	33,966,500.00	34,170,400.00
35410	Бичиг хэргийн материал	-	298,000.00
35420	Аж ахуйн материал	14,920,500.00	14,349,600.00
35440	Түлц, шатах тослох материал	11,296,700.00	7,744,700.00
35460	Хүнсний материал	7,749,300.00	11,778,100.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	683,788,218.53	670,802,875.05
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	683,788,218.53	670,802,875.05
392	Биет хөрөнгө	672,828,218.53	659,842,875.05
39201	Барилга, байгууламж, орон сууц	684,673,172.16	684,673,172.16
39202	Хуримтлагдсан элэгдэл	(26,100,901.44)	(39,151,352.16)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	27,651,226.00	10,439,975.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(22,855,155.64)	(5,015,983.81)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,167,045.00	12,561,500.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,334,786.81)	(5,227,058.20)
39214	Бусад үндсэн хөрөнгө	649,980.00	649,980.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(228,324.74)	(293,322.74)
39217	Ном	1,205,964.00	1,205,964.00
393	Биет бус хөрөнгө	10,960,000.00	10,960,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	10,960,000.00	10,960,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	721,217,102.53	705,018,852.05
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	721,217,102.53	705,018,852.05
51	Засгийн газрын хувь оролцоо	721,217,102.53	705,018,852.05
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	95,629,950.00	95,629,950.00
51101	Өмч: - төрийн	95,629,950.00	95,629,950.00
512	Хуримтлагдсан үр дүн	568,158,093.01	551,959,842.53
51210	Өмнөх үеийн үр дүн	568,158,093.01	568,158,093.01
51220	Тайланг үеийн үр дүн	-	(16,198,250.48)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	57,429,059.52	57,429,059.52
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	721,217,102.53	705,018,852.05

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	382,396,776.00	385,051,022.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,793,176.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	1,793,176.00	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,793,176.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,793,176.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	380,603,600.00	385,051,022.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	380,603,600.00	380,721,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	30,829,200.00	26,008,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	349,774,400.00	354,713,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	4,329,622.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,329,622.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	401,811,446.52	401,249,272.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	401,811,446.52	401,249,272.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	397,585,296.52	394,612,300.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	285,291,539.00	292,858,800.00
210101	Үндсэн цалин	242,960,339.00	262,054,600.00
210104	Урамшуулал	28,717,800.00	17,190,800.00
210105	Гэрээт ажлын хөлс	13,613,400.00	13,613,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,574,474.00	38,157,007.00
210201	Тэтгэврийн даатгал	25,550,642.00	22,894,207.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,005,957.00	3,815,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,404,766.00	3,052,560.00
210204	Ажилгүйдлийн даатгал	601,192.00	763,140.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,011,917.00	7,631,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,933,250.00	29,253,190.00
210301	Гэрэл, цахилгаан	156,600.00	1,811,190.00
210302	Түлш, халаалт	32,776,650.00	27,442,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,250,900.00	5,183,060.00
210401	Бичиг хэрэг	949,000.00	305,900.00
210402	Тээвэр, шатахуун	2,158,000.00	3,717,260.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	611,000.00	622,900.00
210404	Ном, хэвлэл	429,900.00	140,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	803,000.00	396,700.00
2105	Нормативт зардал	14,760,380.00	9,750,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	109,600.00	80,700.00
210502	Хоол, хүнс	13,182,780.00	9,129,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,468,000.00	540,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	500,000.00

210604	Урсгал засвар	-	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	450,000.00	510,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	110,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,324,753.52	18,399,343.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	165,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,024,000.00	2,064,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,135,753.52	16,335,343.48
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,226,150.00	6,636,972.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,020,700.00	5,914,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,020,700.00	5,914,500.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,205,450.00	722,472.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,205,450.00	722,472.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(19,414,670.52)	(16,198,250.48)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(19,414,670.52)	(16,198,250.48)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	84,669,950.00	106,704.00	1,263,130,133.67		1,347,906,787.67
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	84,669,950.00	106,704.00	1,263,130,133.67	0.00	1,347,906,787.67
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн	10,960,000.00		-667,897,961.54		-656,937,961.54
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	95,629,950.00	57,429,059.52	568,158,093.01	0.00	721,217,102.53
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	95,629,950.00	57,429,059.52	568,158,093.01	0.00	721,217,102.53
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	95,629,950.00	57,429,059.52	568,158,093.01	0.00	721,217,102.53
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-16,198,250.48		-16,198,250.48
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	95,629,950.00	57,429,059.52	551,959,842.53	0.00	705,018,852.05

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	380,603,600.00	385,051,022.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	380,603,600.00	385,051,022.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	380,603,600.00	380,721,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	30,829,200.00	26,008,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	349,774,400.00	354,713,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	4,329,622.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан		4,329,622.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	380,603,600.00	381,701,022.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	380,603,600.00	381,701,022.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	376,377,450.00	375,064,050.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	285,372,100.00	290,634,700.00
210101	Үндсэн цалин	243,040,900.00	259,830,500.00
210104	Урамшуулал	28,717,800.00	17,190,800.00
210105	Гэрээт ажлын хөлс	13,613,400.00	13,613,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,515,200.00	38,958,800.00
210201	Тэтгэврийн даатгал	27,100,300.00	27,415,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,853,700.00	2,885,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,283,000.00	2,308,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	570,700.00	577,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,707,500.00	5,771,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,828,250.00	25,506,690.00
210301	Гэрэл, цахилгаан	1,915,250.00	1,666,690.00
210302	Түлш, халаалт	28,913,000.00	23,840,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,827,400.00	5,254,760.00
210401	Бичиг хэрэг	316,200.00	91,700.00
210402	Тээвэр, шатахуун	4,620,100.00	3,717,260.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	611,000.00	702,900.00
210404	Ном, хэвлэл	229,900.00	140,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	300,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	750,200.00	602,600.00
2105	Нормативт зардал	12,947,400.00	11,762,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	109,600.00	80,700.00
210502	Хоол, хүнс	11,369,800.00	11,158,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,468,000.00	523,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	500,000.00
210604	Урсгал засвар	-	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	450,000.00	530,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	130,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,437,100.00	1,916,000.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,437,100.00	1,916,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,226,150.00	6,636,972.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,020,700.00	5,914,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,020,700.00	5,914,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,205,450.00	722,472.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,205,450.00	722,472.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨНГӨН ҮЙЛГЭЭ (3)=(4)+(5)	-	3,350,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	3,350,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	3,350,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	3,350,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		3,350,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨНГӨН ҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(3,350,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨНГӨН ҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	380,721,400.00	380,008,550.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	380,721,400.00	380,008,550.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	374,806,900.00	374,094,050.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	291,183,800.00	290,634,700.00
210101	Үндсэн цалин	260,379,600.00	259,830,500.00
210104	Урамшуулал	17,190,800.00	17,190,800.00
210105	Гэрээт ажлын хөлс	13,613,400.00	13,613,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,958,800.00	38,958,800.00
210201	Тэтгэврийн даатгал	27,415,500.00	27,415,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,885,800.00	2,885,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,308,600.00	2,308,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	577,200.00	577,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,771,700.00	5,771,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,508,000.00	25,506,690.00
210301	Гэрэл, цахилгаан	1,668,000.00	1,666,690.00
210302	Түлш, халаалт	23,840,000.00	23,840,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,132,500.00	5,074,760.00
210401	Бичиг хэрэг	91,700.00	91,700.00
210402	Тээвэр, шатахуун	3,775,000.00	3,717,260.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	712,300.00	712,300.00
210404	Ном, хэвлэл	130,900.00	130,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	422,600.00	422,600.00
2105	Нормативт зардал	11,762,200.00	11,762,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	80,700.00	80,700.00
210502	Хоол, хүнс	11,158,500.00	11,158,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	523,000.00	523,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	104,700.00	-
210702	Дотоод албан томилолт	104,700.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	530,900.00	530,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ	130,900.00	130,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	400,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,126,000.00	1,126,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,126,000.00	1,126,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,914,500.00	5,914,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,914,500.00	5,914,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,914,500.00	5,914,500.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	380,721,400.00	380,008,550.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	354,713,400.00	354,001,860.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	354,713,400.00	354,001,860.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	26,008,000.00	26,006,690.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	26,008,000.00	26,006,690.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	28.00	29.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	14.00	14.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	11.00
620004	Гэрээт ажилтан	3.00	3.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	59.00	59.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦ	59.00	59.00
630001	Төрийн өмчит ЕБС	59.00	59.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	28.0	29.0
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	15.00	15.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	13.00	14.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		4,320,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		4,320,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		4,320,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		4,140,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		4,140,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		4,329,622.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		4,329,622.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		4,329,622.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Булган сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор У.Ербол гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 19 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Хүүхдийн суралцах, хөгжих үйлсийн өмнө тулгарч буй хичээл сурлагын хоцрогдлыг арилгахын төлөө бүх талын оролцоо, хамтын чармайлт гарган үр дүнтэй ажиллах, сургуулийн удирдлага болон багш нар мэргэжлээрээ тасралтгүй хөгжих зорилго дэвшүүлж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Булган сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 401.8 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 4.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Булган сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 16.2 сая төгрөгөөр буюу 2.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	3462.40	45.60	-3416.8
Урьдчилгаа	0.00	0.00	0.0
Бараа материал	33966.5	34170.4	203.9
Үндсэн хөрөнгө	683788.2	670802.8	-12985.4
Нийт хөрөнгө	721217.1	705018.8	-16198.3
Өр төлбөр	0.00	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	721217.1	705018.8	-16198.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	721217.1	705018.8	-16198.3

Мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Авлагын дансны үлдэгдэл 0.04 сая төгрөг болж 3.4 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны нийгмийн даатгалын шимтгэл, хоол, хүнсний авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 34.2 сая төгрөг болж 0.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд 49.9 сая төгрөгийн бараа материал худалдан авч үйл ажиллагаандаа 49.7 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 670.8 сая төгрөг болж 12.9 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 3.3 сая төгрөгийн хөрөнгийг орлого авч, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 133 дугаар тогтоол, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 38 дугаар тогтоолоор 27.2 сая төгрөгийн хөрөнгийг акталсан байна.

Өр төлбөр дансны эхний үлдэгдэл үлдэгдэлгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 705.0 сая төгрөг болж 16.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 385.0 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 2.6 сая төгрөгөөр 0.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нэмэлт санхүүжилт байна.

Нийт зардал өмнөх оноос 0.5 сая төгрөгөөр буюу 0.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалингийн зардал, байр ашиглахтай холбоотой зардал, нормативт зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлгийн зардлууд байна.

Цалингийн зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, урсгал засварын зардал, урсгал шилжүүлэг өмнөх оноос нэмэгдэж, байр ашиглахтай холбоотой зардал, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, бараа үйлчилгээний бусад зардал өмнөх оноос буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга гараагүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны анх батлагдсан төсөв 350.9 сая төгрөг, тодотгосон төсөв 380.7 сая төгрөг байна. Тодотгосон төсөв нь анх баталснаас 29.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд:

Цалингийн зардлыг 42.7 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 5.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, хүнсний зардлыг 13.0 сая, тээвэр шатахууны зардлыг 2.0 сая, төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын зардлаас 3.0 сая, гэрэл цахилгааны зардлаас 0.4 сая төгрөгөөр бууруулж баталсан байна. Энэ нь анх баталсан төсөвт цалин, урамшууллын зардлыг дутуу баталсантай холботой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 380.7 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 380.0 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг нийт дүнгээр 0.7 сая төгрөгөөр хэмнэж төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Энэ нь үндсэн цалин, дотоод албан томилолт, тээвэр шатахуун зардлын хэмнэлт байна.

Нийт төсвийн 76.5 хувийг цалин, 10.2 хувийг НДШ-ийн зардал, 6.7 хувийг тогтмол зардал, 1.3 хувийг хангамж бараа материалын зардал, 3.0 хувийг норматив зардал, 0.3 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 2 хувийг бусад зардал тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас төсөл хэрэгжүүлэхээр 4.4 сая төгрөгийн санхүүжилт авч хичээл үйлдвэрлэлийн дадлага хийхэд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Булган сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Тус сургуулийн нийт санхүүжилт 380.0 сая төгрөгөөс үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай 329.6 сая төгрөгийн зардлыг хасахад 50.4 сая төгрөгийн зардлыг тэвчиж болох зардал гэж үзээд тогтоолын дагуу 5.0 сая төгрөгийг хэмнэх тооцоо гарч байна.

Тус сургууль нь оны эцэст 0,7 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж төсвийн хэмнэлт гаргасан нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй гэж үзэх үндэстэй байна.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Булган сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь 2021 онд нийт 384.1 сая төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 384.1 сая төгрөгийн 148 мэдээллийг хугацаандаа бүрэн байршуулж, 3 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар цалингийн зардлаас 3.4 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлэхгүйгээр НДШ, татварт илүү шилжүүлж авлага үүсгэсэн зөрчилд албан шаардлага, шилэн дансны цахим хуудаст 4 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй зөрчилд зөвлөмж өгөгдсөн бөгөөд хэрэгжилтийг давтан шалгахад хэрэгжүүлэн ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн зарцуулалтыг цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан түүвэрлэн шалгасан тул гүйцэтгэлийн аудитаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 8.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 8.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Төлбөрийн акт

Байхгүй.

4.3 Албан шаардлага

Аудитаар нийт 3.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1.Тээвэр шатахууны зардалд зарцуулсан 3.7 сая төгрөгийн жагсаалтад хэрэглэсэн албан тушаалтнуудаар гарын үсэг зуруулж баримтжуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодлох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.5-т "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно...", 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалт, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

2.Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-д зааснаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад 50.4 сая төгрөгийн төсвийн 10 хувь 5.0 сая төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцож, 4.3 сая төгрөгийн урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалт, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Байхгүй.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Булган сумын ЕБ-ын 3-р сургууль	2	8.0					2	8.0		

